



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/114/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК  
Гүйцэтгэх захирал С.Энхтөр  
Утас: 95957791  
Цахим хаяг: [director@mindug.mn](mailto:director@mindug.mn)

Аудитын менежер Ц.Номингоо  
Утас: 90098901  
Цахим хаяг: [coo@mindug.mn](mailto:coo@mindug.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	2
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Залруулга .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.2 Албан шаардлага.....	<b>Error! Bookmark not defined.</b>
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ШША	Шүүхийн шинжилгээний алба
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН  
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Д.АРИУНМӨНХ ТАНАА**

2022.08.25 № 113

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Улсын төсвөөс 839,024.7 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 838,984.9 мянган төгрөгийг зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>14,176,215.00</u></b>	<b><u>42,777,626.46</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	36,161.46
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	36,161.46
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	36,161.46
31211	Төрийн сангийн харилцах	-	36,161.46
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	14,176,215.00	42,741,465.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,998,200.00	-
35110	Тусгай зориулалттай материал	4,998,200.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,178,015.00	42,741,465.00
35420	Аж ахуйн материал	8,596,015.00	41,655,465.00
35440	Түлш, шатах тослох материал	-	396,000.00
35460	Хүнсний материал	118,000.00	226,000.00
35470	Бусад хангамжийн материал	464,000.00	464,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,151,509,481.93</u></b>	<b><u>1,126,764,288.58</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,151,509,481.93	1,126,764,288.58
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,139,831,481.93	1,113,786,288.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,147,290,320.85	1,147,290,320.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(83,511,623.16)	(111,348,830.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,129,680.50	61,650,680.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,870,524.88)	(29,193,453.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,712,525.00	81,053,670.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,530,386.41)	(42,840,213.37)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,095,000.00	8,095,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,696,509.97)	(3,145,884.89)
39217	Ном	2,213,000.00	2,225,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	11,678,000.00	12,978,000.00
39301	Програм хангамж	-	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,678,000.00	11,678,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,165,685,696.93</u></b>	<b><u>1,169,541,915.04</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>1,500,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	1,500,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	1,500,000.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	1,500,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,165,685,696.93</u></b>	<b><u>1,168,041,915.04</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,165,685,696.93	1,168,041,915.04

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	56,737,040.00	56,737,040.00
51101	Өмч: - төрийн	56,737,040.00	56,737,040.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,048,216,375.55	1,050,572,593.66
51210	Өмнөх үеийн үр дүн	1,048,075,677.89	(117,469,321.38)
51220	Тайлант үеийн үр дүн	140,697.66	1,168,041,915.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,732,281.38	60,732,281.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,165,685,696.93</b>	<b>1,169,541,915.04</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>630,863,100.00</b>	<b>2,029,529,596.93</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>73,600.00</b>	<b>1,191,504,896.93</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	73,600.00	1,191,504,896.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	73,600.00	1,191,504,896.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,600.00	1,190,504,896.93
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>630,789,500.00</b>	<b>838,024,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	546,700,900.00	695,355,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	695,355,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	546,700,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	160,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	83,928,600.00	142,669,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,928,600.00	142,669,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>630,722,402.34</b>	<b>861,142,681.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>630,722,402.34</b>	<b>861,142,681.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	630,656,566.14	835,361,641.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	410,534,923.94	499,290,337.54
210101	Үндсэн цалин	312,169,523.94	366,996,593.95
210102	Нэмэгдэл	75,186,830.40	102,971,053.38
210104	Урамшуулал	23,178,569.60	29,322,690.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,231,600.00	63,375,800.00
210201	Тэтгэврийн даатгал	39,088,900.00	43,095,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,035,700.00	5,069,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,228,500.00	4,056,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	807,200.00	1,014,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,071,300.00	10,140,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,630,237.86	75,200,050.06
210301	Гэрэл, цахилгаан	5,045,256.46	11,818,013.26
210302	Түлш, халаалт	35,180,835.10	40,282,036.80
210303	Цэвэр, бохир ус	11,404,146.30	23,100,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,551,850.00	4,998,200.00
210401	Бичиг хэрэг	379,700.00	-
210402	Тээвэр, шатахуун	357,150.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	440,000.00	-
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	4,998,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	42,850,850.00	95,657,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	190,000.00	-
210502	Хоол, хүнс	41,207,350.00	95,657,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,453,500.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,618,760.00	30,714,120.00
210604	Урсгал засвар	12,618,760.00	30,714,120.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	117,000.00	-
210702	Дотоод албан томилолт	117,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,321,502.00	1,258,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,321,502.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,258,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	49,799,842.34	64,867,284.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,510,879.00	14,326,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,228,300.00	7,408,301.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,060,663.34	43,132,193.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	65,836.20	25,781,039.94
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	25,777,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	25,777,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	312.14	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	312.14	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	65,524.06	3,639.94
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,524.06	3,639.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>140,697.66</b>	<b>1,168,386,915.04</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	345,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	345,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(345,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>140,697.66</b>	<b>1,168,041,915.04</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>630,789,500.00</b>	<b>839,024,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	1,000,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	1,000,000.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>630,789,500.00</b>	<b>838,024,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	546,700,900.00	695,355,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	695,355,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	546,700,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	160,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	83,928,600.00	142,669,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,928,600.00	142,669,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>594,567,510.00</b>	<b>821,756,538.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>594,567,510.00</b>	<b>821,756,538.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>594,501,673.80</b>	<b>795,975,498.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	410,534,923.94	499,290,337.54
210101	Үндсэн цалин	312,169,523.94	366,996,593.95
210102	Нэмэгдэл	75,186,830.40	102,971,053.38
210104	Урамшуулал	23,178,569.60	29,322,690.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,231,600.00	63,375,800.00
210201	Тэтгэврийн даатгал	39,088,900.00	43,095,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,035,700.00	5,069,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,228,500.00	4,056,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	807,200.00	1,014,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,071,300.00	10,140,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,428,287.86	75,496,440.06
210301	Гэрэл, цахилгаан	5,045,256.46	11,818,013.26
210302	Түлш, халаалт	34,978,885.10	40,578,426.80
210303	Цэвэр, бохир ус	11,404,146.30	23,100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,571,610.00	-
210401	Бичиг хэрэг	453,400.00	-
210402	Тээвэр, шатахуун	350,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	393,210.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	43,390,250.00	95,765,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	160,400.00	-
210502	Хоол, хүнс	41,276,850.00	95,765,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,953,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,522,000.00	30,999,920.00
210604	Урсгал засвар	12,522,000.00	30,999,920.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	117,000.00	-
210702	Дотоод албан томилолт	117,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,032,102.00	1,258,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,032,102.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,258,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,673,900.00	29,789,151.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	893,000.00	21,407,151.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,780,900.00	8,382,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,836.20</b>	<b>25,781,039.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	25,777,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	25,777,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	312.14	3,639.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	312.14	3,639.94

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,524.06	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,524.06	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>36,221,990.00</b>	<b>17,268,161.46</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>36,221,990.00</b>	<b>17,232,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>36,221,990.00</b>	<b>17,232,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	36,221,990.00	17,232,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,221,990.00	17,232,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(36,221,990.00)</b>	<b>(17,232,000.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(0.00)	36,161.46
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	36,161.46

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,165,685,696.93	-1,165,685,696.93
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>-1,165,685,696.93</b>	<b>-1,165,685,696.93</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,168,041,915.04	1,168,041,915.04
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>2,356,218.11</b>	<b>2,356,218.11</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	839,024,700.00	838,984,898.60
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	839,024,700.00	838,984,898.60
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	813,247,300.00	813,207,498.60
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	499,316,600.00	499,290,337.54
210101	Үндсэн цалин	405,842,500.00	366,996,593.95
210102	Нэмэгдэл	72,305,400.00	102,971,053.38
210104	Урамшуулал	21,168,700.00	29,322,690.21
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	63,375,800.00	63,375,800.00
210201	Тэтгэврийн даатгал	43,095,300.00	43,095,300.00

210202	Тэтгэмжийн даатгал	5,069,900.00	5,069,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,056,200.00	4,056,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,014,100.00	1,014,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,140,300.00	10,140,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>75,500,000.00</b>	<b>75,496,440.06</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,500,000.00	11,818,013.26
210302	Түлш, халаалт	43,000,000.00	40,578,426.80
210303	Цэвэр, бохир ус	21,000,000.00	23,100,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>95,769,300.00</b>	<b>95,765,850.00</b>
210502	Хоол, хүнс	95,769,300.00	95,765,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>42,900,000.00</b>	<b>42,899,920.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,900,000.00	11,900,000.00
210604	Урсгал засвар	31,000,000.00	30,999,920.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,258,000.00</b>	<b>1,258,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	1,258,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35,127,600.00</b>	<b>35,121,151.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,727,600.00	26,727,151.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,400,000.00	8,394,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,777,400.00</b>	<b>25,777,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,777,400.00</b>	<b>25,777,400.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,777,400.00	25,777,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>839,024,700.00</b>	<b>839,024,700.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>839,024,700.00</b>	<b>839,024,700.00</b>
122005	Орон нутгийн төсвөөс	839,024,700.00	839,024,700.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>39,801.40</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго "Бага насны хүүхдийн бие бялдар, нийгэмшихүй, оюун ухаан, урлаг, уран сайхан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх таатай орчинд танхим болон зайнаас суралцах үйлийг дэмжихэд оршино" гэсэн зорилгын хүрээнд иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот "Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах"
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай"
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал "Заавар батлах тухай"
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дугаар тушаал "Заавар батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудиторгүй/ шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,856.2 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	36.2	36.2
Бараа материал	14,176.2	42,741.5	28,565.2
Үндсэн хөрөнгө	1,151,509.5	1,126,764.3	(24,745.2)
Нийт хөрөнгө	1,165,685.7	1,169,541.9	3,856,218.11
Өр төлбөр	-	1,500.0	1,500.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,165,685.7	1,168,041.9	2,356.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,165,685.7	1,169,541.9	3,856.2

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,398,666.5 мянган төгрөгөөр буюу 222 хувиар өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндсэн

хөрөнгийн эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн.

Мөн бараа материалын эхний үлдэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоотойр “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах” чиглэлийн дагуу өөрчлөлтүүд хийгдсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 230,420.3 мянган төгрөг буюу 37 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, нэмэгдэл, байр ашиглалттай холбоотой тогтмол, бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 88,755.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,569.8 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 54,450.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 15,067.4 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 767,558.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 696,355.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 71,203.6 мянган төгрөгөөр бууруулж, 696,355.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 696,355.1, орон нутгийн төсвөөс 142,669.6, туслах үйл ажиллагааны орлого 1000.0 нийт 839,024.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 821,756.5 мянган төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн 36.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	95,769.3	95,765.8	3.5	99.93%
2	81823-Боловсролын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр	1,700.0	1,700.0	0	100%
3	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,700.0	1,700.0	0	100%
4	81834- Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	483,351.10	483,344.60	6.5	100%
5	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	109,667.30	109,641.00	26.3	99.98%

6	83602- ЗГ болон ЗД нөөц хөрөнгөөс хуваарилсан	1,000.0	1,000.0	0	100%
<b>НИЙТ</b>		<b>696,335.1</b>	<b>696,318.8</b>	<b>36.3</b>	<b>99.9%</b>

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор Б.Бүзмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер С.Энхтөр, хяналтыг Сүхбаатар аймаг дахь аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК–д 2023 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 9,460.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,095.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.11, 15.2.32-т зардлыг хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд түлш, халаалтын зардал 1,104.2 мянган төгрөг, гэрэл, цахилгааны зардал 5,965.8 мянган төгрөг, цэвэр болхир усны зардал 822.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түлш халаалны зардал:* Эдгээр байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд өмнөх оноос дунжаар 10.9 хувиар нэмэгдсэн нь 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал бага гарч байсан бол тайланд онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Цэцэрлэг нь 2022 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой.” заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын цэцэрлэгт завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 61,890.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 36,085.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 25,804.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Аудитаар өгсөн албан шаардлага болон зөвлөмжийг 100% биелүүлсэн байна.

##### Хүснэгт 3 Шийдвэрийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	36,085.9	2	36,085.9	100%
Зөвлөмж	5	25,804.2	5	25,804.2	100%
Нийт дүн	7	61,890.1	7	61,890.1	100%

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 75,175.52 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 72,892.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,283.0 мянган төгрөгийн дүнгээр үр дүнгийн тайланд залруулга хийлээ.

##### 5.1 Залруулга

Залруулсан: Үр дүнгийн тайлангийн урсгал засвар, хичээл үйлдвэрлэлийн зардлыг дутуу илэрхийлснийг, анхан шатны баримттай ажил гүйлгээг тулган залруулсан.

##### 5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтаар батлагдаагүй 72,892.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалт, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Худалдан авалтын мэдээллийг татварын нэгдсэн системд мэдээлсэн эсэхийг шалгах, мэдээлээгүй тохиолдолд харилцагч байгууллагад хандан системд шивүүлэх албан шаардлага өгсөн.



<b>Дүн</b>	1	0	-	-	-	-	1	0
------------	---	---	---	---	---	---	---	---